



Захиргааны худалдааны
актын улсын тогтоо
2019 оны 12 дугаар 20
цэвэр

БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 11 сарын 29 өдөр


Дугаар 11/11

Номгон

Г Бичил худалдаа, ажил үйлчилгээний орлогын
албан татварын хэмжээг тогтоох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2-ын "д", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.4, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эзлижит XYIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Бичил худалдаа, ажил үйлчилгээний орлогын албан татварын хэмжээг хавсралтаар тогтоож, баталсугай.
2. Тогтоосон албан татварыг ногдуулах ажлыг холбогдох хууль, журмын дагуу үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.
3. Тогтоолыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, "Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл"-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлсүгай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дунг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.



1190039

Аймгийн ирээдийн Төлөөлөгчдийн Хурлын
2019 сны 11 дүгээр сарын 29-ний өдрийн ээлжит
ХVIII хуралдааны 18/14 дүгээр тоогооны хавсралт



**БИЧИЛ ХУДАЛДАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН-ХЭМЖЭЭ**

Нэг: Хувиараа зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний хувьд

1.1. Хот хооронд

Утга	Хувь хэмжээ	Төгрөгөөр
Бага оврын автобус /16 хүртэл хүний суудалтай/	5 хувь	21000
Дунд оврын автобус /16-30 хүртэл хүний суудалтай/	7 хувь	29400
Том оврын автобус /31-ээс дээш/	10 хувь	42000

1.2. Сум хооронд

Бага оврын автобус /15 хүртэл хүний суудалтай/	5 хувь	21000
Дунд оврын автобус /16-30 хүртэл хүний суудалтай/	6 хувь	25200
Том оврын автобус /31-ээс дээш/	9 хувь	37800

1.3. Нийтийн тээвэр

Автобус үйлчилгээ	5 хувь	21000
-------------------	--------	-------

Хөөр: Ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүний хувьд

3 тн хүртэл даацтай	5 хувь	21000
3-10 хүртэл тн-ын даацтай	5 хувь	21000
10-40 хүртэл тн-ын даацтай	7 хувь	29400
40-еес дээш тн-ын даацтай	10 хувь	42000

Гурав: Ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүнд

Ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүн	1 хувь	4200
Ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй явуулын худалдаа үйлчилгээ эрхэлж байгаа хувь хүн	5 хувь	21000